

болно. Иймд судалгааны баг болон Улаанбаатар хотын захиргаа нь ангиалн цуглуулах тогтолцоог дараах хоёр үе шаттайгаар нэвтрүүлэхээр шийдвэрлэв.

Нэгдүгээр үе шат:


- Хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах (хог цуглуулах цагийн хуваарийг тогтоох)
- Хог хаях журам нэвтрүүлэх

Хоёрдугаар үе шат:

- Ангиалан цуглуулах тогтолцоо нэвтрүүлэх нь тохиромжтой эсэхийг судлах

9.7.2 Хамруулах бүс

Туршилтын төслийг 28,000 орчим хүн амтай Чингэлтэй дүүргийн 1-ээс 6 дугаар хорооны орон сууцны хороололд хэрэгжүүлнэ. Тэдгээр хороод нь Улаанбаатар хотын төв хэсэг болох бөгөөд орон сууц болон ахуйн үйлчилгээний газрууд хоорондоо холилдсон бүс нутаг болно. Дараах зургаар цэнхэрээр тэмдэглэсэн нь аж ахуй нэгжүүд болон дэлгүүрүүд, улаанаар тэмдэглэсэн нь орон сууцны барилгууд болно.



Зураг 9-7: Төслийн хамрагдах хүрээ

9.7.3 Холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлага

Хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоонд олон байгууллагууд татагдан холбогдсоноос хойш холбогдох байгууллага тус бүр төслийг саадгүй хэрэгжүүлэхийн